

Үндэслэл

МУ-ын Засгийн Газар улс орны эдийн засгийн өсөлтийг тодорхойлохдоо макро эдийн засгийн тогтвортой байдал, эдийн засгийн сэргэлтийн үйл явц, санхүү мөнгөний секторын тогтвортой байдал зэрэг гол гол үзүүлэлтүүдэд үндэслэсэн.

Түүнчлэн Дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, Эдийн Засгийн Хөгжлийг Дэмжих болон Ядуурлыг Бууруулах Стратеги, Монголын Ядуурлыг Бууруулах Стратеги зэрэг баримт бичгүүдэд макро эдийн засгийн тогтвортой байдал, хувийн секторын үр ашигтай байдал, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилт болон хувийн сектор тэргүүлсэн үндэсний хөгжлийг бий болгох нөхцлийг бүрдүүлэх зэрэг асуудлуудыг чухалчлан үзсэн билээ.

Хувийн секторын хөгжлийг дэмжихийн тулд гадны капиталыг татах нь зайлшгүй чухал бөгөөд гадаадын шууд хөрөнгө оруулалтад ямар хөнгөлөлт үзүүлэх вэ гэдэг асуудал Монгол улсын хувьд тулгамдсан асуудал болж байна.

Иймд Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА) МУ-ын Засгийн Газрын хүсэлтийн дагуу "Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийг 2010-2013 онд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Төслийн зорилго

Энэхүү техник хамтын ажиллагааны төсөл нь хөрөнгө оруулалтын үйлчилгээг сайжруулах, түүнд гүйцэтгэх судалгааны үүргийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэнээс гадна Гадаад Харилцааны Яам, Гадаадын Хөрөнгө Оруулалтын Газар зэрэг төрийн байгууллагууд болон хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой.


Хүлээгдэж буй үр дүн

1. Монгол улсын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг судалгааны үр дүнд үндэслэн боловсруулна.
2. Гадаадын Хөрөнгө Оруулалтын Газар (ГХОГ) -ын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааг сайжруулах шинжилгээ хийнэ.
3. Холбогдох байгууллагуудтай хамтран ажилласны үндсэн дээр ГХОГ-ын хөрөнгө оруулалтын үйлчилгээний ажлын төлөвлөгөө сайжирна. (тухайлбал мэдээллийн менежмент, тоон мэдээллээр хангах болон Нэг Цэгийн Үйлчилгээ).

Үйл ажиллагааны үндсэн чиглэл

1. Төслийн удирдлага болон оролцооны ач холбогдлын талаар Монголын талд сурталчлах.
2. Хувийн секторын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох суурь судалгаа явуулж үр дүнг нь хөрөнгө оруулалтыг дэмжих үйлчилгээнд тусгах.
3. "Хөрөнгө оруулалтын бодлогын хамрах хүрээ" аргачлалаар хөрөнгө оруулалтын бодлого, үйл ажиллагааны өнөөгийн байдлыг тодорхойлох.
4. Бусад орны хөрөнгө оруулалтын агентлагуудыг харьцуулсан судалгаа, шинжилгээ хийх.
5. Япон улсад сургалт, гуравдагч оронд туршлага судлах аялал зохион байгуулах.
6. Төслийн талаар Монгол, Японы иргэдэд сурталчлах, мэдээллийг үр дүнтэй ашиглах зорилгоор вэб сайт ажиллуулах.
7. Бизнесийн болон онолын зөвлөмж авах зорилгоор Зөвлөх баг байгуулах.
8. Төслийн хяналт үнэлгээр тодорхой хугацаанд тогтмол явуулах.

Төслийн бүдүүвч



Төслийн зохион байгуулалт

